



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/198

Булган сум

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,
соён гэгээрүүлэх, судалгааны чиглэлээр
зохион байгуулах үйл ажиллагаанд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт" хөтөлбөр, "Хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардлыг батлах тухай" аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2026 оны 03 дугаар сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, судалгааны чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны зардалд "Амар тайван Булган" хөтөлбөрийн санхүүжилтээс 10,405,800 (арван сая дөрвөн зуун таван мянга найман зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. "Амар тайван Булган" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх ажил, хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010264

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 18 -ны/ний өдрийн
А/198 дугаар захирамжийн хавсралт



**“АМАР ТАЙВАН БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛААС САНХҮҮЖҮҮЛЭХ
АЖИЛ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгө зарцуулах зориулалт	Зохион байгуулах нэгж	Хэмжээ	Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	2023,2024,2025 оны байдлаар гэмт хэрэг давтамжтай өссөн Булган, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Баяннуур, Орхон, Рашаант сум, Хялганат тосгонд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах үйл ажиллагааны зардал	Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн инновацын судалгаа хөгжүүлэлтийн хүрээлэн	6 суманд зохион байгуулах зардал	3,000,000
2	“Эрх зүйн боловсрол” үйл ажиллагааны зардал	Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газрын дэргэдэх Ахмадын зөвлөл	Аймгийн 16 сум 1 тосгоны төрийн алба хаагч, иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн сургалтын зардал	3,924,800
3	Булган аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй “Харилцан хүндэтгэе” уриа дор зохион байгуулагдаж буй “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хууль зүйн салбар”-ын эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалтын зардал	Хууль эрх зүйн хэлтэс, хууль хяналтын болон тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд	Үйл ажиллагаанд оролцогч нарын цайны зардал	2,041,000
4	Залилах гэмт хэрэг, үе тэнгийн дээрэлхэлт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлэлцүүлгийн зардал	Хууль эрх зүйн хэлтэс, Булган сумын ИТХ-ын төлөөлөгч, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, нийгмийн ажилтнууд	Үйл ажиллагаанд оролцогч нарын цайны зардал	440,000
5	Ерөнхий боловсролын сургуулийн 10,11 дүгээр ангийн сурагчдаас сонгон сургагч багш бэлтгэх	Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Боловсролын газар	Сургагч багшийн зардал	1,000,000
Нийт дүн				10,405,800

--o00o--